<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	498,064.30	29,045.00
223001	Бусад хөрөнгө	498,064.30	29,045.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	148,000.00	80,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	148,000.00	80,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	13,457,939.10	3,078,485.96
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,903,403.50	1,866,728.83
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,599,347.80	1,562,673.13
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	304,055.70	304,055.70
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	11,253,068.60	1,071,717.99
132001	Орон нутгийн төсвөөс	11,253,068.60	1,071,717.99
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	26,467.00	12,183.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,467.00	12,183.50
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	275,000.00	127,855.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	127,855.64
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	175,000.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	226,657.60
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	589,015.76
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	9.0	9.0
610001	Төсвийн байгууллага	6.0	6.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	3.0	3.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	142.0	138.0
620001	Удирдах ажилтан	16.0	9.0
620002	Гүйцэтгэх ажилтан	82.0	85.0
620003	Үйлчлэх ажилтан	37.0	36.0
620004	Гэрээт ажилтан	7.0	8.0
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	720.0	700.0
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	540.0	520.0
630001	Төрийн өмчит ЕБС	540.0	520.0
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	180.0	180.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	180.0	180.0
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	1315.0	7277.0
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	1160.0	313.0
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	155.0	6964.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>142.0</b>	<b>138.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.0	7.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	57.0	57.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.0	5.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.0	17.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	39.0	37.0
650010	Гэрээт ажилтан	7.0	8.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.0	7.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	123881.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123881.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92802.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35186.2
210101	Үндсэн цалин	12855.7
210102	Нэмэгдэл	21945.5
210104	Урамшуулал	385.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4904.3
210201	Тэтгэврийн даатгал	3345.0
210202	Тэтгэмжийн даатгал	389.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	311.9
210204	Ажилгүйдлийн даатгал	78.0
210205	Эрүүл мэндийн даатгал	779.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1912.0
210401	Бичиг хэрэг	919.0
210402	Тээвэр, шатахуун	963.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
210404	Ном, хэвлэл	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0
2105	Нормативт зардал	41724.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37956.7
210502	Хоол, хүнс	3767.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2720.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	470.0
210604	Урсгал засвар	2250.0
2107	Томилолт, зочны зардал	140.0
210702	Дотоод албан томилолт	140.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	955.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	955.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5260.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3450.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1810.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31079.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26150.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25450.0

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4929.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4929.0
223001	Бусад хөрөнгө	0.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	124409.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124409.1
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50.0
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8872.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110011.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5474.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	528.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Түмэнцогт сумын засаг дарга Г.Энхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15 -аас 2021 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сумын эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй, газар тариалан, ЖДҮ, уул уурхайн салбарт тэргүүлэх ач холбогдол өгч эрчим хүч, дэд бүтцийн бодлогыг урт хугацаанд боловсруулан үе шаттай шийдэх бөгөөд үр дүн нь эдийн засгийн өсөлтөөр илэрнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох, ОНХС, сумын төсөв уул уурхайн орлого, зарцуулалтыг иргэдэд нээлттэй болгож, үр дүнг дээшлүүлэх

- Төсвийн нэгдмэл байдлыг ханган, сахилга батыг сайжруулж, төсөв, хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгон үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горим шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулах
- Бүх талын хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулж, хөрөнгө оруулалтыг татах бодлого баримтлах
- ХАА-н салбарыг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шинжлэх ухааны ололт, шинэ технологид суурилсан гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай болгон Эрүүл мал, Эрүүл хүнс зорилтын хүрээнд хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай бүтээгдэхүүн, түүхий эдээр хангах
- Орон нутагт эрчим хүч, харилцаа холбоо, зам тээврийн тогтвортой ажиллагааг бүрэн хангаж, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээний сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх
- Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний мэдлэг чадварыг сайжруулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уурхайг хөгжүүлэх
- Аялал жуулчлалыг бүс нутгийн хэмжээнд хөгжүүлэх
- Боловсролын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Түмэнцогт сумын засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрэх магадлалтай байна.

2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна. Түмэнцогт сумын засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ

### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 3,192.1 сая төгрөгийн зардлын 1.5 хувь буюу 47.8 сая, гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 35.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 360.2 сая, эцсийн үлдэгдэл 797.4 сая төгрөг болж 437.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	0.3	0.6	0.3
Төрийн сангийн харилцах	359.9	797.4	437.5
Хадгаламж	-	-	-
<b>Дүн</b>	<b>360.2</b>	<b>798.0</b>	<b>437.8</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 796.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.6 сая төгрөг арилжааны банкны дансанд, 0.5 сая төгрөг эрүүл мэндийн төвийн харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн харилцах дансанд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого 109.9 сая, ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт 479.0 сая, төсөвт байгууллагуудын жилийн эцсийн харилцахын үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлсэн 53.6 сая, төлөвлөснөөс давсан татварын болон татварын бус орлого 154.4 сая төгрөг тус тус үлдэгдлээр үлджээ.

**3.5.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 262.9 сая, эцсийн үлдэгдэл 228.3 сая төгрөг болж, 34.6 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	46.1	56.0	9.9
Хувь хүмүүсээс авах авлага	216.8	172.3	-44.5
<b>Дүн</b>	<b>262.9</b>	<b>228.3</b>	<b>-34.6</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 147.8, ОНХС-ийн авлага 12.6, ЗДТГ нэмэлт санхүүжилтийн төслийн авлага 2.8, Түмэнцогт ОНӨААТҮГ-ын авлага 32.6, Ус-Дулаан ААТҮГ-ын НӨАТ-ын авлага 12.1, ЭМТ-ийн даатгалын санхүүжилтийн авлага 17.5, ЕБС авлага 1.5, хүүхдийн цэцэрлэгийн авлага 1.4 сая төгрөг нийт авлага 228.3 сая төгрөг байна. Тухайлбал: Түмэнцогт ОНӨААТҮГ-ын 32.6 сая төгрөгийн авлага нь сангийн аж ахуй тарах үед үүссэн, барагдуулах боломжгүй олон жилийн насжилттай авлага байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Авлага үүсгэсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйд зөвлөмж хүргүүлсэн. /ЕБС/
- Өмнөх онуудад үүсэж, санхүүгийн тайланд олон жил илэрхийлэгдсэн авлага 20,813.0 мянга, өр төлбөр 8,224.3 мянга нийт 29,037.3 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийг барагдуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн /Түмэнцогт ОНӨААТҮГ/

**3.5.3 Бараа материал**

Бараа материалын эхний үлдэгдэл 270.4 сая, эцсийн үлдэгдэл 347.1 сая төгрөг болж, 76.8 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Тусгай зориулалтын материал	27.3	29.1	1.7
Эм боох материал	19.6	42.5	22.9
Бичиг хэргийн материал	1.7	1.5	-02
Аж ахуйн материал	81.2	35.0	-46.2
Түлш тослох материал	0.001	0.001	-
Хүнсний материал	0.8	1.3	0.5
Бусад хангамжийн материал	114.1	175.5	61.2
Мал амьтад	22.8	59.7	36.9
Нөөцийн бараа	2.5	2.5	-
<b>Дүн</b>	<b>270.4</b>	<b>347.1</b>	<b>76.8</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 347.1 сая төгрөгийн үлдэгдэлд аж ахуй, тусгай зориулалт, эм боох материал, бусад хангамжийн материал болон мал амьтад гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн 78.5 хувийг Эрүүл мэндийн төв, Түмэнцогт Ус дулаан ОНӨҮГ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Хоол хүнсний материалыг нөөцөлж, төсөвт төвлөрүүлээгүйд төлбөрийн акт тогтоов /ЕБС/
- Хүнсний бараа материал 30.7 сая төгрөгийг бөөн дүнгээр бүргэж тайлагнасанд зөвлөмж хүргүүлэв /ЕБС/
- Бараа материалын эхний эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй он дамжсан үлдэгдэлтэйд зөвлөмж хүргүүлэв /ЕБС/
- Худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна. /ЕБС/

**3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,655.2 сая, эцсийн үлдэгдэл 6,380.5 сая төгрөг болж, 274.9 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	5,344.1	5,088.9	-255.4
Тээврийн хэрэгсэл	57.5	37.5	-20.0
Машин тоног төхөөрөмж	284.8	284.8	0.0
Тавилга эд хогшил	123.5	123.5	0.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйл			0.0
Номын фонд	8.5	8.5	0.0
Бусад үндсэн хөрөнгө	66.4	66.4	0.0
Программ хангамж	654.3	654.3	0.0
Бусад биет бус хөрөнгө			
Бусад хөрөнгө	106.5	106.5	0.5
Биологийн хөрөнгө	9.6	10.1	
<b>Дүн</b>	<b>6,655.2</b>	<b>6,380.5</b>	<b>-274.9</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 56.3 сая, балансас шилжүүлэн авсан 37.1 сая, үнэ төлбөргүй хандиваар нэмэгдсэн 72.7 сая нийт 166.1 сая төгрөгөөр нэмэгдэж, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр 228.2 сая төгрөгийн хөрөнгө актлан, 7.5 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 330.8 сая, эцсийн үлдэгдэл 116.8 сая төгрөг болж, 214.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбогдсон өглөг	36.4	11.5	-24.9
Байгууллага төлөх өглөг	114.3	12.1	-102.2
Хувь хүмүүст төлөх өглөг	25.8		-25.8
Татварын өглөг /ТӨҮГ/	17.2		-17.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	8.1		-8.1
Дансны өглөг /ТӨҮГ/	11.1		-11.1
Урьдчилж орсон орлого	117.9	93.2	-24.2
<b>Нийт дүн</b>	<b>330.8</b>	<b>116.8</b>	<b>-214.0</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны эцэст ажилчидтай холбоотой өглөг 11.5, байгууллага төлөх өглөг 12.1, урьдчилж орсон орлого дансны өглөг 93.2 сая нийт 116.8 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Үүнээс: “Ус дулаан” ОНӨҮГ- т үнэ төлбөргүй ирсэн 93.2 сая төгрөгийн хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэж, жил бүр капиталжуулж байгаа нь өр төлбөрт нөлөөлсөн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд зөвлөмж хүргүүлэв /ЕБС,ЗДТГ,ЭМТ, ИТХ/
- Бараа материалын дансанд 17.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, мөн 2019 онд үнэ төлбөргүй шилжин ирсэн 2.5 сая төгрөгийн түрээсийн номыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд тус тус бүртгэсэн, нийт 20.4 сая төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгээсэнд зөвлөмж хүргүүлэв. /ЕБС/

### 3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,767.3 сая, эцсийн үлдэгдэл 3,104.3 сая төгрөг болж, 337.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,694.4	2,694.4	0
Хуримтлагдсан үр дүн	1,785.8	2,031.9	246.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,849.6	2,849.3	-
<b>Дүн</b>	<b>7,329.8</b>	<b>2,849.3</b>	<b>246.1</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын дансны үлдэгдэл буурахад тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

### 3.5.7 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 366.5, үнэ төлбөргүй хүлээн авсан 804.6, зээлийн хүүгийн орлого 16.0, борлуулалтын орлого 11.7, түрээсийн орлого 11.6, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,560.5, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 231.6, нэмэлт санхүүжилтийн орлого 78.4, орон нутгийн төсвөөс санхүүжих 738.5, эрүүл мэндийн даатгалын сангаас 21.6 сая нийт 3,766.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

### 3.5.8 Зардлын данс

Борлуулалтын өртөг 9.7, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,567.6, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 196.4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23.8, хангамж, бараа материалын зардал 61.1, нормативд зардал 74.4, эд хогшил, урсгал засварын зардал 18.4, томилолт, зочны зардал 2.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 349.5, бараа үйлчилгээний бусад зардал 781.7, бусад урсгал шилжүүлэг 23.5, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 92.9, үйл ажиллагааны бус зардалд 415.7 сая нийт 3,617.5 сая төгрөгийн зардал тайлагнасан байна.

Зардлын данстай холбоотой холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй 4.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- Тамгын газрын даргад үр дүнгийн урамшуулал 0.3 сая төгрөгийг хууль эрх зүйн шийдвэргүй олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ЗДТГ/
- Засаг даргын томилдог багийн дарга, санхүү төрийн сангийн албаны дарга нарт үр дүнгийн урамшуулал 1.4 сая төгрөгийг тамгын газрын даргын шийдвэрээр олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв. /ЗДТГ/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй 31.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв./ЗДТГ/

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 08 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 64 сая төгрөг, татварын бус орлого 220.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 366.5 сая төгрөгийн орлого төвлөрч, 82.5 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Бүүрсан/
НИЙТ ОРЛОГО	284.0	366.5	82.5
ТАТВАРЫН ОРЛОГО	64.0	135.4	71.4
Хувь хүний орлогын албан татвар	35.0	60.0	25.0
Үйл ажиллагааны орлого	1.0	12.3	11.3
Хөрөнгийн орлого	29.0	38.5	9.5
Шууд бус орлого	5.0	5.0	-
Хөрөнгө борлуулсны орлого		4.1	4.1
Хөрөнгийн албан татвар	1.5	55.3	53.8
Бууны албан татвар	1.5	1.4	-0.1
Малын тоо толгойд ноогдуулах татвар	-	53.9	53.9
Бусад татвар (төлбөр, хураамж)	27.5	104.3	76.7

Улсын тэмдэгтийн хураамж	1.5	2.7	1.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.0	3.3	0.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	-	1.0	1.0
Газрын төлбөр	23.0	15.2	-7.8
Газрын төлбөр	23.0	15.2	-7.8
Агнуурын нөөц ашигласны төлбөр	-	81.9	81.9
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>220.0</b>	<b>146.8</b>	<b>-73.0</b>
Хүү, торгуулийн орлого	25.0	48.9	23.9
Нэр заагдаагүй орлого	195.0	97.9	97.9

Орон нутгийн орлого 82.5 сая төгрөгөөр давсан нь тус суманд хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 25.0 сая, үйл ажиллагааны орлого буюу ноосны урамшууллаас 11.3 сая, хөрөнгийн орлого буюу хадгаламжийн хүүгийн орлого 9.5 сая, хөрөнгө борлуулсны орлого 4.1 сая, малын тоо толгойд ноогдуулсан татвар 53.9 сая, агнуурын нөөц ашигласны төлбөр 81.9 сая, хүү торгуулийн орлого 23.9 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.2 сая, хог хаягдлын хураамж 0.3 сая төгрөгөөр давж биелсэн бол бууны албан татвар 0.1 сая, газрын төлбөр 7.8 сая, ангилагдаагүй бусад орлого 97.0 сая төгрөгөөр тасарсан байна. Иймд төсвийн орлогын төлөвлөлтийг эдийн засгийн суурь үзүүлэлттэй уялдуулах, тооцоо судалгаагүй, бодитой бус орлого төлөвлөхгүй байхад анхаарах нь зүйтэй байна.

### Төсвийн төлөвлөлт

Түмэнцогт сумын засаг даргын 2021 онд татварын орлогыг 64.0 сая, татварын бус орлогыг 220.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Түмэнцогт сумын засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 3,457.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,811.8 сая төгрөгийг урсгал зардалд, 498.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 148.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,071.7, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,562.6, Эрүүл мэндийн даатгалын сангаас 12.2, үндсэн үйл ажиллагааны орлогоос 127.9, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 304.1 сая нийт 3,078.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,717.2 сая төгрөг буюу 21.7 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн болон Ковид 19 цар тахлаас шалтгаалан зарим төсөл арга хэмжээг дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

### Нэмэлт санхүүжилт

ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8.8, дээд шатны төсвийн захирагчаас 110.0, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5.6 сая нийт 124.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, урамшуулал, шимтгэлд 35.2 сая, хангамж, бараа материалын зардалд 1.9 сая, нормативд зардалд 41.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 2.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0,9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 5.2 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 31.1 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 0.6 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 128 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийн хугацаа болоогүй, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Түмэнцогт сумын засаг даргад 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100
Нийт	2	-	2	-	-	-	100

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 орон нутгийн тусгайн сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланг үе шатны ажилд хэсэгчлэн хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, “Хязгаарлалттай” 1 /*Ерөнхий боловсролын сургууль*/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,020.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 274.8 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 1.1 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 39.1 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 705.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэний аргаар санхүүгийн тайланд толилуулах, ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ЗДТГ-т бүртгэх бус тус санд нь захиалагчийн зүгээс бүртгэж байгаа байдлыг хамруулан авч үзэх

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 4.1. Орлогын данстай холбоотой

#### 4.1.1 Илрүүлэлт:

Тус сумын нийт орлого нь 82.5 сая төгрөгөөр давж биелсэн нь татварын болон татварын бус орлогыг бодиттой төлөвлөгөөгүйтэй холбоотой байна.

#### 4.1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн орлогыг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу иж бүрэн боловсруулж, төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой гаргахад ажлаа төлөвлөх.

#### **4.2 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:**

Илрүүлэлт:

4.2.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.2.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

#### 4.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

#### 4.3.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

#### 4.3.2 Эрсдэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

#### 4.3.3 Өгсөн зөвлөмж

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.